



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 1/149

Номгон

Г Техникийн хяналтын үзлэг, тээврийн Г
хэрэгслийн албан татвар хураалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.10, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг жилийн турш холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудын шаардлагыг хангуулсны үндсэн дээр аймгийн Цагдаагийн газар, Татварын хэлтэс, сумдын Засаг даргын Тамгын газартай хамтарч чанартай зохион байгуулсугай.

2. Техникийн хяналтын үзлэг явуулах аймгийн комиссыг нэгдүгээр, сумдад ажиллах салбар комиссыг хоёрдугаар, үзлэгийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тус аймгийн иргэд, байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байгаа автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн автозам ашигласны төлбөр хураамжийг төсөвт бүрэн төвлөрүүлэхийг аймгийн Татварын хэлтэс (С.Рэнцэндагва)-т, татвар хураалтыг орон нутагт зохион байгуулсан ажлын үр дүнг харгалзан сумдын Засаг дарга нарт үнэлэлт дүгнэлт өгч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс (Б.Батбаяр)-т, ажлын үр дүнг улирал тутам танилцуулахыг Комиссын дарга (Б.Наранбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

4 Иргэд, байгууллага, түүнчлэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэг, албан татвар, албан журмын даатгалд бүрэн хамруулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байдал, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, орон нутгийн автозам ашигласны төлбөр төлөлт, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хэрэгжилтэд бүтэн жилийн турш


• 625010445

хяналт шалгалтыг тасралтгүй явуулж, зөрчлийг тухай бүр арилгуулахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Мөнхбаяр), Автотээврийн төв (С.Батцэрэн) нарт үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

7.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний А/220 дугаар Захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын ... дугаар
сарын ... ний өдрийн ... дүгээр
Захирамжийн ... дүгээр хавсралт



ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ АЙМГИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

Б.Наранбаяр

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Т.Ерэнбаяр

Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн
дарга, Цагдаагийн хошууч

Н.Батдорж

Аймгийн Татварын хэлтсийн Бичил татвар
төлөгчтэй харилцах тасгийн дарга

Д.Магвансүрэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
Зүйн хэлтсийн Зам тээврийн хяналтын Улсын
ахлах байцаагч

Т.Норовринчин

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө
оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

С.Батцэрэн

Автотээврийн төвийн дарга

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2025 оны 03
дугаар сарын 12-ний өдрийн 119 дугаар
Захирамжийн 027 дугаар хавсралт



ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ХУВААРЬ

№	Сум, багийн нэр	Хоног	Хугацаа
1	Баянхонгор сум		01 дүгээр сарын 02-ноос 12 дугаар сарын 31
Говийн чиглэл			
2	Жинст	2	4 дүгээр сарын 14 -өөс 4 дүгээр сарын 15
3	Богд	3	4 дүгээр сарын 16 -аас 4 дүгээр сарын 18
4	Баянлиг	4	4 дүгээр сарын 19 -өөс 4 дүгээр сарын 22
5	Баянговь	3	4 дүгээр сарын 23-аас 4 дүгээр сарын 25
6	Шинэжинст	3	4 дүгээр сарын 27-оос 4 дүгээр сарын 29
7	Баян-Өндөр	2	4 дүгээр сарын 30-аас 5 дугаар сарын 01
8	Баянцагаан	3	5 дугаар сарын 02-оос 5 дугаар сарын 04
9	Баацагаан	2	5 дугаар сарын 05-аас 5 дугаар сарын 06
Хангайн чиглэл			
10	Бөмбөгөр	2	5 дугаар сарын 9-оос 05 дугаар сарын 10
11	Бууцагаан	2	5 дугаар сарын 11-ээс 05 дугаар сарын 12
	Баянбүрд баг /Бууцагаан сум/	1	05 дугаар сарын 13
	Бууцагаан	1	05 дугаар сарын 14
12	Хүрээмарал	2	5 дугаар сарын 15-аас 05 дугаар сарын 16
13	Баянбулаг	2	5 дугаар сарын 17-оос 05 дугаар сарын 18
14	Гурванбулаг	2	5 дугаар сарын 19-өөс 05 дугаар сарын 20
15	Заг	2	5 дугаар сарын 21-ээс 05 дугаар сарын 22
16	Жаргалант	3	5 дугаар сарын 23-аас 05 дугаар сарын 25
17	Галуут	2	5 дугаар сарын 26-аас 06 дугаар сарын 27
18	Баян-Овоо	1	5 дугаар сарын 28
19	Эрдэнэцогт	2	5 дугаар сарын 29-өөс 5 дугаар сарын 30
20	Өлзийт	2	6 дугаар сарын 02-оос 6 дугаар сарын 3
21	Шаргалжуут /Баянхонгор сум/	1	6 дугаар сарын 4
	Уул уурхайн байгууллагууд	2	6 дугаар сарын 6-аас 06 дугаар сарын 7
	Сумдад ажиллах нийт хоног	49	



ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ САЛБАР КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Сумдад ажиллах комисс:

Д.Баттулга Автотээврийн төвийн Техникийн хяналтын үзлэгийн
инженер

С.Амармөнх Автотээврийн төвийн Техникийн хяналтын үзлэгийн
инженер

Автотээврийн хяналтын мэргэжилтэн, Тээвэр зохицуулагч

Сумын Засаг даргын Захирамжаар томилогдсон салбар комисс (Татварын
хяналтын улсын байцаагч, сум дундын Цагдаагийн тасаг, сумын Цагдаагийн хэсэг,
багийн Засаг дарга нар)

-----oOo-----